



ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛ, ТҮҮНИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ



ТОВЧ ТАЙЛБАР

Монгол Улс “зорчих эрхийг хязгаарлах ял” хэмээх шинэ тутам ялыг Эрүүгийн хуульдаа тусгаж “гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрх бүхий байгууллагын хяналтад байлгаж өөрийн оршин суух газраас явах болон тодорхой газар очихыг хориглох, шүүхээс тогтоосон чиглэлээр зорчих, эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэйгээр оршин суух газраа өөрчлөх, зорчих үүргийг нэг сараас таван жил хүртэл хугацаагаар хүлээлгэхийг хэлнэ” хэмээн тодорхойлсон.

Дэлхий нийтэд зорчих эрхийг хязгаарлах буюу цахим гав, цахилгаан хяналтын төхөөрөмж ашиглан хяналт тавих ялыг хэрэглэх техникийн боломж 1960-аад оны сүүлээр бүрдэж, шүүхийн практикт 1980-аад оноос хэрэглэгдэх болсон билээ. Өнөөдөр 20 гаруй улсад энэ төрлийн ялыг хэрэглэж байгаа бөгөөд АНУ, ИБУИНВУ, Австрали, Шинэ Зеланд, Канад зэрэг Англо-Америкийн эрх зүйн тогтолцоотой улс, Герман, Бельги, ОХУ зэрэг эх газрын эрх зүйн тогтолцоотой улсуудыг дурдаж болно.

Манай улсын хувьд хорих ялын хэрэглээ өндөр түвшинд хүрсэн өнөөгийн практикийг халахад зорчих эрхийг хязгаарлах ял чухал түлхэц үзүүлнэ хэмээн үзэж байгаа билээ. Гэсэн хэдий ч энэ төрлийн ялыг анх удаа хэрэглэх гэж байгаагийн зэрэгцээ энэ чиглэлийн судалгаа, шинжилгээ дутмаг байна. Тиймээс ННФ-ын захиалгаар НОМОС хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл (ХХН)-ийн судлаачид “Зорчих эрхийг хязгаарлах ял, түүнийг хэрэгжүүлэх боломж” сэдвийн хүрээнд зорчих эрхийг хязгаарлах ялын тухай ойлголт, түүний үндсэн суурь нөхцөл, хэрэгжүүлэх арга зам, үр нөлөө, төрийн байгууллагуудын уялдаа холбоо, өсвөр насны хүнд хэрэглэх асуудал зэргийг нарийвчлан судалж тогтоохыг зорьсон билээ.

Энэхүү тойм нь дээрх судалгаанд тулгуурласан бөгөөд боловсруулах явцад судалгааны эх сурвалж болсон хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орсонтой холбогдуулан зайлшгүй шаардлагатай зарим мэдээллийг шинэчиллээ. Уг тоймоор судалгааны гол үр дүн, санал, зөвлөмжийг уншигчдад хүргэхийг зорьсон ба судалгааг бүрэн эхээр нь www.forum.mn сайтаас татаж үзнэ үү.

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Зорчих эрхийг хязгаарлах нь Монгол Улсын хувьд шинэ төрлийн ял бөгөөд үүнийг хэрэглэж, хэрэгжүүлж байсан туршлага байхгүй тул ялын үр нөлөө, хэрэгжүүлэх арга зам, туршлагыг судлахдаа харьцуулсан судалгааны аргыг ашиглалаа. Үүнд, эрх зүйн бүлийн тодорхой төлөөлөл болсон улс орнуудын Эрүүгийн хуулиудад зорчих эрхийг хязгаарлах ялыг хуульчлан томъёолсон байдал, түүнийг гүйцэтгэх туршлага, үр нөлөөтэй хэрэглэх арга замыг судалж, манай улсын Эрүүгийн хууль дахь зорчих эрхийг хязгаарлах ялын зохицуулалттай харьцуулан судалж дүгнэлт, зөвлөмж гаргалаа. Эх газрын эрх зүйн бүлээс Франц, Герман зэрэг эрх зүй өндөр хөгжсөн орнууд мөн Нийтийн эрх зүйн бүлийн орнуудаас Англи, Америк; пост-социалист эрх зүйн бүлийн орнуудаас ОХУ, Унгар, Латви, Литва; холимог эрх зүйн бүлээс БНСУ, Япон зэрэг орнуудын Эрүүгийн хуульд харьцуулсан дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Шинэчлэн найруулсан эрүүгийн хуулийн үзэл баримтлал болоод түүнийг хэлэлцэн батлах, төсөл боловсруулах үеийн холбогдох баримт бичгүүд, НҮБ-ын Мансууруулах бодис, гэмт хэрэгтэй тэмцэх албанаас эрхлэн боловсруулсан Эрүүгийн загвар хууль болон эрх зүйн өндөр хөгжилтэй гаднын орнуудын Эрүүгийн хуулиуд, холбогдох бусад хууль тогтоомж, Монгол Улсын

¹ Зүйл 5.5 (1), Монгол Улсын Эрүүгийн хууль, 2015.12.03

нэгдэн орсон Олон улсын гэрээ конвенциуд, Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль болон шинэчлэн найруулсан Эрүүгийн хуульд нийцүүлэн боловсруулсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Хууль сахиулах ажиллагааны тухай хуулиуд болон бусад холбогдох хууль, тогтоомжийг судлах замаар хууль тогтоогчийн санаа, зорилгыг тодорхой болгох, уг ялын үр нөлөөг тодруулах зорилгоор баримт бичгийн судалгааны арга зүйг ашиглалаа.

СУДАЛГААНЫ ДҮН

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫН ХЭРЭГЛЭЭ, ҮР НӨЛӨӨНИЙ ТУХАЙД: Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид 20 төрлийн 208 гэмт хэрэг зүйлчилснээс хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэргээс бусад бүх төрлийн 139 гэмт хэрэг буюу нийт гэмт хэргийн 67 хувьд зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахаар заажээ.² Харин судалгаанд хамрагдсан орнуудын хувьд бусдын эрх, эрх чөлөө, эрүүл мэнд, нийгмийн хэв журамд халдах төрлийн гэмт хэргүүдэд л энэ төрлийн ялыг оногдуулдаг байна. Тиймээс Эрүүгийн хуульд хэт олон төрлийн гэмт хэрэгт зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулахаар заасан нь энэ төрлийн ялыг хэрэглэдэг бусад орноос ялгаатай болжээ. Үүний зэрэгцээ зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэхээр заасан зарим төрлийн гэмт хэрэгт тухайн ял үр нөлөөтэй эсэхэд эргэлзээ төрөхөөр байна. Тухайлбал, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт энэ ялыг оногдуулахаар заасан нь гэмт этгээд гэмт үйлдлээ үргэлжлүүлэх боломжтой байна. Энэ нь гэмт хэрэг үйлдсэн хүн буюу хуулийн этгээдийг цээрлүүлэх, зөрчигдсэн эрхийг сэргээх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх гэсэн эрүүгийн хариуцлагын зорилготой нийцэхгүй байна.

Энэ ялын нийгэмд үзүүлэх эерэг нөлөө нь давтан гэмт хэргийн гаралтыг бууруулах явдал бөгөөд уг ялыг амжилттай хэрэглэж байгаа улсуудын туршлага үүнийг батлан харуулж байна. Манай улсын хувьд хорих ял шийтгэгдсэн этгээдийн 67 хувь нь дахин гэмт хэрэг үйлддэг гэсэн статистик бий. Энэ нөхцөлд нийгмээс нь тусгаарлахгүйгээр, ажил хөдөлмөр эрхлэх, сурч боловсрох боломжийг

хязгаарлахгүйгээр эдлүүлдэг сайн талтай зорчих эрхийг хязгаарлах ял нь тодорхой ахиц гаргана гэж үзэж байна.

ЗОРЧИХ ЭРХИЙГ ХЯЗГААРЛАХ ЯЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ БОЛОМЖИЙН ТУХАЙД: Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэглэхэд байршил тогтоох төхөөрөмж буюу телефон утасны шугам, эсхүл GPS төхөөрөмж ашиглах тул улс орныг хамарсан хөдөлгөөнт интернетийн сүлжээ шаардагдах бөгөөд хяналтын програм хангамж, төхөөрөмж, боловсон хүчин бэлтгэх зардал зэргийг оролцуулан анх нэвтрүүлэхэд нэлээд өндөр зардалтай боловч хэрэгжих шатандаа хорих ялыг хэрэгжүүлэхэд гарах зардлаас даруй 5-10 дахин хямд болох нь энэ төрлийн ялыг хэрэглэж байгаа улс орнуудын туршлагаас харагдаж байна. Түүнчлэн ялтныг нийгэмшүүлэхэд гарах зардлыг хэмнэх ач холбогдолтой юм. Зарим улс орон энэ төрлийн ялыг шинээр нэвтрүүлэхэд гарах зардлыг хувийн хэвшлийн байгууллагуудтай үр дүнтэй хамтран ажиллах замаар шийдэж буй туршлага бий. Тухайлбал Шотланд, Латви, Литва улсуудын энэ чиглэлийн үйлчилгээ үзүүлдэг томоохон компаниудтай гэрээтэй ажилладаг байна. Энэ нь эхний шатанд гарах зардлыг шийдэхэд чухал ач холбогдолтой.

Эрүүгийн хуульд зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хугацаа 5 жил, өсвөр насны хүнд энэ ялыг оногдуулахдаа хугацааг хоёр дахин багасгахаар заажээ. Дээд хугацаа 5 жил байгаа нь бусад орны жишгээс даруй 1,7 дахин урт байна. Судалгаанд хамрагдсан улсуудын хувьд дээд тал нь 3 жил байгаа бөгөөд энэ нь дохио дамжуулах төхөөрөмжийн насжилт, мөн төхөөрөмж зүүх хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийг тооцсонтой холбоотой байдаг ажээ.

ЗӨВЛӨМЖ

- Хэт хавтгайруулан бүх төрлийн гэмт хэрэгт хорих ялын альтернатив байдлаар тусгасныг эргэн харж, бусад орны туршлагад тулгуурлан ялыг оновчтой ногдуулах;
- Эрүүгийн хуульд зорчих эрхийг хязгаарлах ялын дээд хугацаа 5 жил байгааг тоног төхөөрөмжийн насжилт, хүний эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөлөлтэй холбогдуулан бууруулах;
- Зорчих эрхийг хязгаарлах ялыг хэрэгжүүлэхдээ энэ чиглэлийн үйлчилгээ үзүүлдэг томоохон компаниудтай технологи түрээслэх гэрээ байгуулж, хамтран ажиллах боломжийг судлан, хэрэгжүүлэх;
- Төлбөрийн чадваргүй, тэр дундаа өсвөр насны ялтанд зорчих эрхийг хязгаарлах ял оногдуулах боломжит хувилбарыг хуульд тусгах.

Түүнчлэн зорчих эрхийг хязгаарлах ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих тоног төхөөрөмжийн зардлыг ялтан хариуцан төлөхөөр зохицуулсан бөгөөд хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх нөхцөлийг хуульд заагаагүй тул төлбөрийн чадваргүй ялтныг энэ төрлийн ялаар шийтгэх боломжгүй болжээ. Бусад улс оронд төлбөрийн чадваргүй ялтны төлбөрийг шийдэх тодорхой зохицуулалттай байдаг байна. Тухайлбал, АНУ-д өсвөр насны ялтны гэр бүл орлого багатай бол хөнгөлөлт олгох, эсхүл нийтэд тустай ажил хийж төлбөрөө барагдуулах сонголтыг өгдөг.

² УИХ-аас 2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр Эрүүгийн хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийг тусгасан.

СУДЛААЧИД:

Ж.ЭРДЭНЭБУЛГАН, Хууль зүйн ухааны доктор, профессор (Ph.D), МУИС-ийн ХЗС-ийн захирал

Д.БАДАМ, Хууль зүйн ухааны доктор (Ph.D), МУИС-ийн ХЗС-ийн нийтийн эрх зүйн тэнхимийн дэд профессор

Л.ГАЛБАДАР, Хууль зүйн ухааны магистр (LL.M), Монголын хуульчдын холбооны Эрүүгийн эрх зүйн хорооны тэргүүн, “Өмгөөллийн Номос” ХХН-ийн өмгөөлөгч

М.МӨНХБАТ, Хууль зүйн ухааны магистр (LL.M), МУИС-ийн ХЗС-ийн нийтийн эрх зүйн тэнхимийн ахлах багш

М.МӨНХБААТАР, Хууль зүйн ухааны магистр (LL.M), “Өмгөөллийн НОМОС” ХХН-ийн өмгөөлөгч

СУДАЛГААНЫ ТОЙМЫГ БОЛОВСРУУЛСАН:

Б.ХИШИГСАЙХАН, ННФ-ын Засаглалын хөтөлбөрийн менежер